



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 176.

Улаанбаатар хот

Г. Чимирийн нэрэмжит шагнал олгох журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.12 дахь заалт, 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Судалгаа, шинжилгээнд сууринсан хууль тогтоо ажиллагааг хөгжүүлэх, парламентат ёс, парламент судлал, үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үнэ цэнэтэй, томоохон бүтээл туурвисан эрдэмтэн, судлаачдыг хөхиүлэн дэмжих зорилгоор Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Бяраагийн Чимирийн нэрэмжит шагнал бий болгосугай.

2. Б.Чимирийн нэрэмжит шагнал олгох журмыг хавсралтаар баталсугай.

3.Б.Чимирийн нэрэмжит шагналыг 2015 оноос эхлэн олгосугай.

4.Б.Чимирийн нэрэмжит шагналын өргөмжлөл, медалийн загвар гаргах, хэвлүүлэхтэй холбогдсон зардал, дагалдах мөнгөн урамшууллыг зохих журмын дагуу төсвөөс гаргахыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт зөвшөөрсүгэй.

ДАРГА

3.ЭНХБОЛД



Монгол Улсын Их Хурлын даргын
2014 оны 17-гоот захирамжийн
хавсралт

Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Б.Чимирийн нэрэмжит шагнал горилох бүтээлийг нэр дэвшүүлэх, шалгаруулах, шагнал гардуулахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Судалгаа, шинжилгээнд суурилсан хууль тогтоох ажиллагааг хөгжүүлэх, парламентат ёс, парламент судлал, үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үнэ цэнэтэй, томоохон бүтээл туурвисан эрдэмтэн, судлаачдыг хөхиүлэн дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Бяраагийн Чимирийн нэрэмжит шагнал (цаашид "шагнал" гэх) -ыг жил бүр нэг хүнд, эсхүл судлаачдын нэг багт олгоно.

1.3. Шагнал нь Монгол Улсын Их Хурлын даргын гарын үсэг бүхий өргөмжлөл, Б.Чимирийн дүрс бүхий медаль, 5,000,000.00 (таван сая) төгрөгийн мөнгөн урамшууллаас бүрдэнэ.

1.4. Шагналыг жил бүр Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Их Хурлын дарга Төрийн ордонд гардуулна.

Хоёр. Нэр дэвшүүлэх, шалгаруулах

2.1. Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага судлаач, эрдэмтдийн бүтээлийг Б.Чимирийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэх бөгөөд холбогдох бичиг баримтыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ.

2.2. Шагналд нэр дэвшсэн бүтээл нь дотоод, эсхүл гадаадын нэр хүнд бүхий эрдэм шинжилгээний хэвлэлд нийтлэгдсэн, эсхүл бие даасан ном, бүтээл болон хэвлэгдсэн байна.

2.3. Нэр дэвшүүлсэн байгууллагын ирүүлсэн хүсэлт, протокол, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичиг нь эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэг бүхий байна.

2.4. Нэр дэвшсэн бүтээлийн үр дүн, дэвшүүлсэн шинэ санаа, санал дүгнэлт, үзэл баримтлал, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр нь тодорхой тооцоо үндэслэл, нотолгоо баримтаар нотлогдсон байна.

2.5. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулагдсан судлаач, эрдэмтдээс бүрдсэн баг З хүртэл нэр дэвшигчдийг сонгон шалгаруулж Монгол Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлд хэлэлцүүлэхээр оруулна.

2.6. Монгол Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл энэ журмын 2.5-д заасан нэр дэвшигчдээс нэг нэр дэвшигчийг шалгаруулах бөгөөд Монгол Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж, шагналыг олгоно.

2.7. Шагнал олгох шаардлага хангасан бүтээл ирээгүй гэж энэ журмын 2.5-д заасан баг, эсхүл Монгол Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл үзвэл тухайн жилд шагналыг олгохгүй байж болно.

2.8. Шагнал хүртсэн судлаач, эрдэмтдийн багийн бүтээл, холбогдох бусад баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хадгалах бөгөөд бүтээлийг хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтээр мэдээллийн эх үүсвэр бүрдүүлэхэд ашиглана.

Гурав. Бүрдүүлэх бичиг баримт

3.1. Шагналд нэр дэвшүүлсэн бүтээлийн талаар дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.1.1. нэр дэвшүүлж хүсэлт ирүүлсэн байгууллагын эрдмийн зөвлөл, төрийн болон төрийн бус байгууллагын удирдах, төв байгууллагын хурлын протокол, шийдвэр;

3.1.2. нэр дэвшигчийн эрдэм шинжилгээний бүтээлийн баталгаажсан жагсаалт;

3.1.3. нэр дэвшиж байгаа бүтээлийн товч танилцуулга, гарсан үр дүн;

3.1.4. нэр дэвшсэн бүтээлийн талаар тухайн салбарын хоёр эрдэмтний шүүмж;

3.1.5. нэр дэвшсэн бүтээлээс дотоод, эсхүл гадаадын судалгааны бүтээлд ишлэл авсан тухай баримт;

3.1.6. нэр дэвшигчийн анкет;

3.1.7. ажил байдлын тодорхойлолт.

-----оо-----